МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль

Эдийн Засгийн Боловсрол Холбоо

# ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

№2. 2000

**МОНГОЛ УЛС: Эдийн засгийн судалгааны хөгжлийн үе шат**




Улаанбаатар. 2000

**Сэтгүүлийн редакцийн зөвлөл**

Дарга: **Б.Сувд**

Гишүүд:

**Д.Дагвадорж**
**П.Лувсандорж**
**Г.Миеэгомбо**
**Э.Сайнбилэг**
**Б.Сайнжаргал**

Н/Б дарга **Б.Энхтуяа**

**ХАЯГ:**
Улаанбаатар 46-А/121
Монгол Улсын Их Сургууль
Эдийн засгийн Сургууль

**УТАС: 350997**

**ФАКС: 976-1-350994**

**И-МЭЙЛ:**
**enkhtuya@ses.edu.mn**

© 2000. Эдийн засгийн боловсрол холбоо МУИС-ийн Эдийн засгийн сургууль

# АГУУЛГА

Өмнөх үг ........ 3

Зохиогчид ........ 4

1. К.Аксолтан "Капитал, капиталын хөдөлгөөн" ........ 5
2. Д.Бадарч "Үндэсний үйлдвэрлэлийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал" ........ 12
3. Д.Ганзориг "Эдийн засгийн өсөлтөнд улсын зардал нөлөөлөх нь" ........ 18
4. Р. Гансүх "Гадаадын хөрөнгө оруулалтын орчинг бүрдүүлэх арга зүйн асуудал" ........ 24
5. Э.Гүргэмжав, Н.Батнасан "Экспортыг баримжаалсан бодлого уу, эсвэл импортыг орлох бодлого уу" ........ 33
6. Д.Дуламсүрэн "Үнэт цаасыг хөрөнгө оруулалтын эх сурвалж болгон ашиглах боломжууд" ........ 39
7. М.Женис "Инфляц" ........ 46
8. Д.Намсрай "Ажилгүйдэл, инфляцийн хамаарал" ........ 51
9. Э.Наран "Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөтгөх арга зам" ........ 59
10. В.Нацагдорж "Төгрөгийн ханшны буурал ба хөрвөх чадвах" ........ 67
11. Д.Пүрэв "Монголын боловсролын тогтолцооны менежментийн зарим асуудал" ........ 75
12. А.Энхбат "Монгол улсын эдийн засгийн байдал, цаашдын хандлага" ........ 80

Танилцуулга: МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн хүрээлэн ........ 88

Хавсралт: Магистр, докторын сургалтын шинэ журам ........ 92

# Editorial Board

Editor in chief: **B.Suvd**

Board members:

**D.Dagvadorj**
**P.Luvsandorj**
**G.Miegombo**
**E.Sainbileg**
**B.Sainjargal**

Secretary **B.Enkhtuya**



**ADDRESS:**
Ulaanbaatar 46-A/121
National University of Mongolia
School of Economic Studies

**TELEPHONE: 350997**

**FAX: 976-1-350994**
**E-MAIL:**
**enkhtuya@ses.edu.mn**



© 2000. Economic Education Association, School of Economic Studies, NUM


# CONTENTS


Foreword/Preface ........................................ 3

About authors ........................................ 4

1. K.Aksoltan "Capital&transfer of Capital" ........ 5

2. D.Badarch "National industry development and present conditions" ................................ 12

3. D.Ganzorig "Effect of expenditures on economic growth" ........................................ 18

4. R.Gansukh "Problems of greating an environment for foreign investments" .................. 24

5. E.Gurgemjav, N.Batnasan "An export promoting or import substituting policy?" ........... 33

6. D.Dulamsuren "Opportunities for using securities as source of investment" .............. 39

7. M.Jenis "Inflation" ........................................ 46

8. D.Namsrai "Relationship between unemployment and inflation" ........................................ 51

9. E.Naran "Ways of expanding economic and trade cooperation between Mongolia and China" ........................................................ 59

10. V.Natsagdorj "Inflation of tugrik and its convertibility" ................................................ 67

11. D.Purev "Problems of Mongolian educational system management" ................................ 75

12. A.Enkhbat "Economic Situation of Mongolia and its further trends" .................................. 80

Introduction: The Economics Research Institute, National University of Mongolia ....... 88

Appendix: New regulations for Master's and Doctor's degree education ........................... 92




# ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн засгийн сургууль,Эдийн засгийн боловсрол холбоо хамтран гаргаж буй ЭДИЙН ЗАСАГ: онол практик сэтгүүлийн 2000 оны 2 дахь дугаарыг Эдийн засгийн хүрээлэн бэлтгэж хэвлүүлэв.

Сэтгүүлийн энэхүү дугаарт Монгол орны эдийн засгийн зангилаа асуудлуудаар хийгдсэн эрдэм шинжилгээний ажлуудын тодорхой үр дүнгүүдээс уншигч та бүхэнд толилуулж байна.

Ажилгүйдэл нэмэгдэхэд инфляц буурдаг урвуу хамааралтай эдийн засгийн хоёр өөр үйл явц манайд болохоор шууд хамааралтай, өөрөөр хэлбэл инфляц ч буураад, ажилгүйдэл ч буураад байгаа бололтой. Анхаарал татсан энэ асуулт хариулт шаардаж байгаа юм.

Капиталын хөдөлгөөн, мөнгөний хөрвөх чадвар, хүн капиталын хөгжил, эдийн засгийн өсөлтийн зарим асуудлаар хийгдсэн судалгааны үр дүн та бүхэнд таалагдана байх.

Үнэт цаасны зах зээл, олон улсын худалдааны онолыг Монголын нөхцөлд бүтээлчээр хэрэглэх оролдлого хийсэн залуу эрдэмтдийн бүтээл бидний сонирхолыг татаж байна. Ялангуяа үнийн мэдрэмж, худалдааны нөхцлийг монголын экспорт, импортын барааны бүлгүүдээр судалсан ажлыг нэн ач холбогдолтой шинэ судалгаа гэж болно.

Цаашид, эдийн засгийн шинжлэх ухааны орчин үеийн чиглэлүүдээр төрөлжсөн дугаар гаргах болно. Эдийн засгийн онол, практикийн асуудлуудаар хийсэн сонирхолтой судалгааныхаа үр дүнгээс манай сэтгүүлд нийтлэж болно.

***Б. Сувд***
***П. Лувсандорж***

# ЗОХИОГЧИД

1. **Кылыш Аксолтан.** Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph), дэд профессор. Хөгжлийн эдийн засаг, өмч хувьчлал, нөөц хөгжлийн асуудлаар судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээлүүд: "Шилжилтийн үеийн хөдөөгийн асуудал" МУИС, Эрдэм шинжилгээний бүтээл, УБ 1997, "Монгол Улсын газрын өмчлөл" Өвөр Монголын зүүн хойт Ази судлалын институтын сэтгүүл, 1997 (хятад хэлээр), "Reform in industries and shareholding company" Problems of economic development (abstract from papers), 1996, УБ.
2. **Доржсүрэн Бадарч.** Доктор (Ph), Үйлдвэрлэл Худалдааны Яам, Үйлдвэрлэлийн бодлого зохицуулалтын газрын дарга. Хөгжлийн эдийн засгийн чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Ноосны Аж үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлого" 2000, УБ.
3. **Дондогдорж Ганзориг.** Секторын эрхлэгч, Доктор (Ph), Хөгжлийн эдийн засгийн чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Технологийн хөгжлийн үндсэн асуудал" МУИС-ийн эрдэм шинжилгээний бүтээл 1997 №1, "Монгол улс, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа" Өвөр Монголын зүүн хойт Ази судлалын институтын сэтгүүл 1998, №1, "Зээлийн өрийг зохицуулах асуудал" Санхүүгийн мэдээ сонин 2000 он, №10.
4. **Равсал Гансүх.** Докторант. Хөгжлийн эдийн засаг чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Валютын ханшны системийн сонголт, солилцооны ханшийг зохицуулж буй механизм, нөлөөлж буй хүчин зүйлүүд".
5. **Эрдэнэдалай Гүргэмжав.** МУИС-ийн ЭЗС-ийн маркетинг, олон улсын худалдааны тэнхмийн эрхлэгч, доктор (Ph), дэд профессор. Олон улсын худалдаа, бизнес, маркетингийн чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд гаргасан бүтээл: "Гадаад худалдаа" ном 1997, УБ, "Аялал жуулчлалын маркетинг" ном 1999, УБ, "Олон улсын худалдаа" ном 2000, УБ.
6. **Намсрай Батнасан.** Доктор (Ph), гадаад худалдааны чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Импортын тарифийн зохицуулалтын зарим асуудлууд" 2000, УБ, "Гадаад худалдааны либералчлал" УБ, 2000.
7. **Даарийжав Дуламсүрэн.** Үнэт цаасны хорооны ахлах мэргэжилтэн. Доктор (Ph.d) Санхүүгийн менежмент, үнэт цаасны зах зээлийн чиглэлээр судалгааны ажил хийдэг.
8. **Мурат Женис.** Эрдэм шинжилгээний ажилтан, магистр. Хөгжлийн эдийн засаг, инфляцийн чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Хүнийг хөгжүүлэх нь бүтээмжийн зангилаа асуудал" Засгийн газрын мэдээ. 1997 №228. "Ажлын цаг хороггдуулснаар эрчим хүчнээс 347.7 сая төгрөг хэмнэнэ. "Засгийн газрын мэдээ". 1997 №123.
9. **Дэмбэрэлсамбуу Намсрай.** Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга. Доктор (Ph). Хөдөлмөрийн эдийн засгийн чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Хөдөлмөрийн зах зээлийг зохицуулах асуудалд" МУИС-ын эрдэм шинжилгээний бүтээл 1997.
10. **Э.Наран.** БНХАУ, Өвөр Монголын Их Сургуулийн Хөрш улс судлах газрын Эдийн засаг судлах тэнхмийн эрхлэгч, дэд профессор. Олон улсын эдийн засгийн судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд нийтлүүлсэн бүтээл: Хятад-Монголын харилцаа. 1998 Хөх хот.
11. **Вандаг Нацагдорж.** Эрдэм шинжилгээний ахлах ажилтан. Доктор (Ph), дэд профессор. Хөгжлийн эдийн засаг, зах зээлийн санхүүгийн асуудлаар судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Хөгжлийн эдийн засаг" УБ, 2000. Өмч хувьчлал ба зах зээл "Ил товчоо" 1998 №3.
12. **Дампил Пүрэв.** Эрдэм шинжилгээний ахлах ажилтан. Доктор (Ph.D) Хөгжлийн эдийн засаг, хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, хөгжил чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: "Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал" Хөх Монгол XXI зуун, 1999, №9, "Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн технологийн хөгжлийн асуудал" ОУ Судлалын төвийн эрдэм шинжилгээний бүтээл, 2000 он.
13. **Амаржаргал Энхбат.** Санхүү эдийн засгийн яамны мэргэжилтэн. Эдийн засгийн бодлогын ухааны магистр, Хөгжлийн эдийн засаг чиглэлээр судалгааны ажил хийдэг.